



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 01 сарын 30 өдөр

Дугаар 35

Улаанбаатар хот

Г Үлгэрчилсэн дүрэм, бүтэц батлах тухай Г

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4 дэх хэсэг, Засгийн газрын 2015 оны “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. УИХ-ын 2009 оны 95 дугаар тогтоолоор батлагдсан Биеийн тамир, спортын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын газрын үлгэрчилсэн дүрмийг 1 дүгээр, аймаг, дүүргийн биеийн тамир, спортын газрын бүтцийг 2 дугаар, нийслэлийн биеийн тамир, спортын газрын бүтцийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Үлгэрчилсэн дүрэм, бүтцийн дагуу биеийн тамир, спортын газрын дүрэм, бүтцээ харъяалах аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргатай зөвшилцөн батлуулж, шаардагдах хүний нөөцийг үе шаттайгаар бүрдүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн биеийн тамир, спортын газрын дарга нарт үүрэг болгосугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

080126

Эрүүл мэнд, спортын сайдын 2015  
оны 01 сарын 30-ны өдрийн 35 дугаар  
тушаалын 1 дүгээр хавсралт

**АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН  
ҮЛГЭРЧИЛСЭН ДҮРЭМ**


**Нэг. Нийтлэг үндэслэл**


1. Биеийн тамир, спортын газар (цаашид Газар гэх )-ын үйл ажиллагааны чиглэл, эрх, үүрэг хэрэгжүүлэхтэй холбогдох харилцааг энэхүү дүрмээр зохицуулна.
2. Газар нь үйл ажиллагаандаа Биеийн тамир, спортын талаар төрөөс баримтлах бодлого, Биеийн тамир, спортын тухай хууль, Үндэсний баяр наадмын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Биеийн тамир, спортыг хөгжүүлэх цогц хөтөлбөр, эрүүл мэнд, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон нутгийн өөрөө удирдах байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргын шийдвэр, бусад холбогдох хууль тогтоомж, стандарт, холбогдох дүрэм, журам, зааврыг мөрдлөг болгоно.
3. Байгууллагын ажиллагсдын болон дотоод ажлын зохион байгуулалтыг байгууллагын дотоод журам, үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээгээр зохицуулна.

**Хоёр. Үйл ажиллагааны чиглэл**

1. Газар нь өөрийн харьяалах нутаг дэвсгэрийн хүн амд үзүүлэх биеийн тамир, спортын ажил, үйлчилгээг удирдан зохион байгуулах, орон нутгийн онцлог, хүн амын хэрэгцээнд нийцсэн бодлого, хөтөлбөр, стратеги төлөвлөлт боловсруулан батлуулж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хэрэгжүүлэх;
2. УИХ, Засгийн газар, биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон орон нутгийн захиргааны байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх, мэдээллээр хангах, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;
3. Биеийн тамир, спорттой холбогдон гарсан бодлого, хөтөлбөр, тушаал, шийдвэрийг бусад салбар, аж ахуйн нэгж, байгууллага, спортын холбоод, клуб, иргэдэд сурталчлан таниулах, оролцоог хангах арга хэмжээг зохион байгуулах;


4. Тухайн нутаг дэвсгэрийн хүн ам, ялангуяа хүүхэд залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, байгууллага хамт олон, хөдөлгөөний хомсдолд өртөх магадлал бүхий бүлэг, биеийн тамир, спортоор хичээллэдэггүй бүлгийг биеийн тамир, спортын арга хэмжээнд татан оролцуулах, биеийн тамир, спортын үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсвийн төсөлд тусгуулах, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт тавих, санхүүгийн мэдээ, тайланг нэгтгэх, үнэлэлт, дүгнэлт өгөх;
5. Орон нутгийн онцлогт тохирсон биеийн тамир, спортын төрлийг хөгжүүлэх;
6. Олон улсын болон дотоодын спортын тэмцээн уралдаан зохион байгуулах, түүнд багш дасгалжуулагч, тамирчин, байгууллагын зохистой хамтын ажиллагаа бий болгох, тамирчидаа бэлтгэн оролцуулах, амжилт гарах нөхцлийг бүрдүүлэх, идэвхи санаачлагыг өрнүүлэх механизм бий болгон ажиллах;
7. Орон нутгийн онцлогт тохируулан өсвөрийн шигшээ багийг 8-аас доошгүй төрлөөр аймаг, нийслэлийн Засаг даргын баталсан журмын дагуу байгуулж, шигшээ багийн сургалт дасгалжуулалтад дэмжлэг үзүүлэх;
8. Харъяалах хүн амын биеийн тамир, спортын эрэлт, хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах төсвийн бус санхүүгийн эх үүсвэр, материаллаг бааз бий болгох ажил зохион байгуулах, санаачлагуудыг дэмжих;
9. Хүн амын тоонд тулгуурлан спортын барилга болон ногоон байгууламж бүхий байгууламж талбай, биеийн тамир, спортын хэрэглэл материалын бодит хэрэгцээг тодорхойлж, 8-12 жилийн төлөвлөлт гарган Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулж ажиллах;
10. Спортын барилга байгууламжийн төлөвлөлтийг хийхдээ ногоон байгууламжтай, иргэдийн амарч, зугаалах ая тухыг бүрдүүлсэн гүйлт, аялал, дугуйн зам, сагсан бөмбөг, хөлбөмбөг, теннис зэрэг спортын задгай талбай бүхий спортын паркийг төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааны үр дүнд бий болгох чиглэлийг барьж ажиллах;
11. Хүн амын тоонд тулгуурласан биеийн тамир, спортын хүний нөөцийн хэрэгцээг тогтоож, аймаг, нийслэл, сум, дүүрэг, хороонд хүний нөөцийг бүрдүүлэх, төрийн бус байгууллага болон бусад салбарт ажиллаж байгаа биеийн тамир, спортын асуудал хариуцсан ажилтанг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллах;
12. Биеийн тамир, спортын чиглэлээр ажиллаж байгаа биеийн тамир, спортын холбоо, клуб, хамтлаг болон аялал, алхалт, чийрэгжилт зэрэг сайн дураар



- 
- байгуулагдсан олон нийтийн биеийн тамирын бүлгүүдэд материаллаг баазын болон мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;
13. Хүн амын бүлэг, нас, ажил, амьдралын онцлог, сонирхолд нийцсэн биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн зөвлөмж, аргачилал боловсруулж, бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоож, хүн амын биеийн хөгжлийн чадваруудыг сайжруулах ажил зохион байгуулах;
  14. Биеийн тамир, спортын ажил, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор хүн ам биеийн тамир, спортоор хичээллэх аюулгүй, эрүүл орчин нөхцлийг хот суурин газрын захиргааны байгууллага болон бусад холбогдох салбар, байгууллагуудтай хамтран байгуулах, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцлийг бүрдүүлэхэд анхаарч ажиллах;
  15. Биеийн тамир, спортын чиглэлээр гарсан стандарт, журам, заавар, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, орон нутгийн холбогдох хяналт шалгалтын байгууллагатай хамтран хяналт шалгалтыг зохион байгуулж, тулгамдсан асуудлыг тогтоох, бэрхшээл, зөрчлийг арилгах арга хэмжээг авах;
  16. Биеийн тамир, спортын статистик мэдээг гаргах, тайлагнах, дүн мэдээнд үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан боловсруулах, тайлагнах, олон нийтэд мэдээлэх;
  17. Биеийн тамир, спортыг хүний эрүүл мэнд, бие бялдрын хөгжил, авъяас чадварт тулгуурлан шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хөгжүүлэх ажил зохион байгуулах;
  18. Биеийн тамир, спортын зарим ажил үйлчилгээг төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх ажлыг судлан хэрэгжүүлэх;
  19. Байгууллагын ажиллагсдын нийгмийн баталгаа, нийгмийн хамгааллын асуудлыг судлан шийдвэрлэх;
  20. Биеийн тамир, спортыг архи, тамхи, допингоос ангид байлгах сурталчилгаа зохион байгуулах, орчин бүрдүүлэх.

#### **Гурав. Удирдлага, зохион байгуулалт**

1. Биеийн тамир, спортын газрын дарга нь Төсвийн менежер байх бөгөөд Засаг даргатай Үр дүнгийн гэрээ байгуулж ажиллана.
2. Газар нь удирдлага, санхүү, аж ахуйн хувьд бие даан ажиллах ба “Биеийн тамир, спортын газар” гэсэн албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.

- 
3. Газар нь харъяа нутаг дэвсгэрийн хэмжээнд биеийн тамир, спортын үйл ажиллагааг бүхэлд нь удирдах ба бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, чанар, хүртээмжийг сайжруулах, хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх, санхүү хөрөнгө нөөцийг хуваарилах, хяналт тавих асуудлыг эрхэлж, Засаг дарга, Эрүүл мэнд, спортын сайдын өмнө хариуцна.
  4. Байгууллагын орон тоог орон нутгийн хүн амын онцлог, хэрэгцээнд тулгуурлан тогтоож, энэхүү үлгэрчилсэн дүрэм, бүтцийн загварыг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг даргын шийдвэрээр дүрэм, бүтэц зохион байгуулалтыг батлуулан ажиллана.
  5. Байгууллага, аж ахуйн нэгж, салбар дундын болон иргэдийн оролцоог хангах ажлыг зохицуулах орон тооны бус зөвлөлтэй байж болно.

### **Дөрөв. Эрх, үүрэг**

#### 4.1. Биеийн тамир, спортын газрын эрх:

1. Харьяалах нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн байгууллагуудад биеийн тамир, спортын чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, шаардлага тавих;
2. Биеийн тамир, спортын чиглэлээрх үйл ажиллагааг орон нутгийн түвшинд зохион байгуулах, тус үйл ажиллагаанд иргэд, олон нийт, аж ахуйн нэгж байгууллагыг татан оролцуулах;
3. Биеийн тамир, спортын улсын төсвийн болон орон нутгийн төсвийн санхүүжилтийн менежментийг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх, орон нутгийн биеийн тамир, спортын үйл ажиллагааны төсвийн бус санхүүжилтийг нэмэгдүүлэх, биеийн тамир, спортын орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулах өгөөжийг нэмэгдүүлэх санаачлан гаргах, өгөөжийг тооцох;
4. Өөрийн орны болон гадаад орны ижил төрлийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ, хэлцэл хийх;
5. Төрийн одон, медаль, салбарын болон нутгийн захиргааны байгууллагын шагналд идэвх зүтгэлтэй, санаачлагатай, үр бүтээлтэй ажиллаж байгаа тамирчин, багш дасгалжуулагчид, албан хаагчид, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын нэрийг дэвшүүлэх, урамшуулах;
6. Хуульд заасан эрхийн хүрээнд ажилтныг томилох, чөлөөлөх, албан тушаалаас нь бууруулах, өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, түр чөлөөлөх, халах;

7. Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагатай хамтын ажиллаганы гэрээ байгуулах, явуулж байгаа тэмцээн уралдааны зохион байгуулалт, гүйцэтгэлд хяналт тавих, мэдээ тайлан авах.

#### 4.2. Биеийн тамир, спортын газрын үүрэг:

1. Биеийн тамир, спортын талаар гарсан бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан ажил үүргийг гүйцэтгэх;
2. Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас гаргасан эрх зүйн акт, стандарт, удирдамж, мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн акт, шаардлагыг хэрэгжүүлэх;
3. Орон нутгийн биеийн тамир, спортын ажил үйлчилгээний, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгаа хийж, тэргүүлэх чиглэл, хөгжлийн хэтийн төлвийг тодорхойлох;
4. Хүн амын бүлэг, нас, ажил, амьдралын онцлогт нийцсэн биеийн тамир, спорт чийрэгжүүлэлтийн ажил, үйлчилгээг зохион байгуулах;
5. Байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, төсвийг үр ашигтай ашиглах, биеийн тамир, спортын заал талбайг ашиглан хийх ажил үйлчилгээний үнэ тарифыг иргэдэд ил тод, нээлттэй байлгах, хяналт тавих;
6. Орон нутгийн биеийн тамир, спортын барилга байгууламж, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хийх, шинэчилэх, бүртгэлийн мэдээний санг байгуулж, ажиллуулах;
7. Хүүхэд өсвөр үе, залуучуудын бие бялдрын хөгжлийг сайжруулах, спортод дуртай болгох, биеийн тамирын хичээлийн үр өгөөжийг сайжруулах талаар холбогдох боловсролын байгууллагатай, хүн амын хөдөлгөөний хомсдлыг бууруулах асуудлаар эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах;
8. Өөрийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, урамшуулан дэмжих чиглэлээр төр олон нийт, хувийн хэвшлийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, хамтран ажиллах;
9. Сумдын биеийн тамир, спортын арга зүйчийг удирдлага, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах;
10. Орон нутагт биеийн тамир, спортын хүний нөөцийг тогтвортой ажиллуулах, мэдлэг мэргэшлийн дээшлүүлэх;
11. Байгууллагын ажиллагсдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг нь хангах арга хэмжээг зохион байгуулах.


Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 01 сарын 30-ны өдрийн 35 дугаар тушаалын 2 дугаар хавсралт



### АЙМАГ, ДҮҮРГИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ҮЛГЭРЧИЛСЭН БҮТЭЦ



Эрүүл мэнд, спортын сайдын  
2015оны 01 сарын 30-ны өдрийн 35  
дугаар тушаалын 3дугаар хавсралт



### НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН БҮТЭЦ

